



**ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ  
ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн  
хэрэгжилтийг хангах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2022 оны тавдугаар сарын 18-ны өдрийн 07 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Дэд захирал, зөвлөхийг ажлаас чөлөөлөхийг Гүйцэтгэх захирал /Н.Удаанжаргал/-д үүрэг болгосугай.
3. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэмжээнд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийн тайланг улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Н.Удаанжаргал/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Б.Батсайхан/-нд даалгасугай.


ДАРГА Ц.ОДХҮҮ





**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2022 ОНЫ  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТОО**

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар  
сарын 24 өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР-883